



ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН
ЗӨВЛӨМЖ

2024.06.17 № 26-05/03

Зөвлөмж хүргүүлэх тухай

Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газар, тусгай сангуудын 2024 оны 5 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг мал хамгаалах сангийн үйл ажиллагаанд чиглүүлэх, муудсан эрсдэлтэй ашиглах боломжгүй гэж үзсэн 6 төрлийн 273 тоо ширхэг 3,552.4 мянган төгрөгийн өвс тэжээлийг тооллогын комиссоор баталгаажуулан, өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэрлүүлэх, устгалтын акт үйлдэж устгах.
2. Бараа материалын тайланг сар бүр гаргаж нягтлан бодогчоор тооцоогоо бодуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" /20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ гэсэн заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.
3. Мал хамгаалах сангийн авлага дансны тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлага бууруулах ажлыг зохион байгуулах.
4. Сумын засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд тусгагдсан 9,787.1 мянган төгрөгийн өр мөн 19,178.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулах.
5. Хоршоо хөгжүүлэх сангийн Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухан сумын иргэдийн Төлөөлөгчдыг хурал тогтооно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 7 сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт албан бичгээр ирүүлэх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧИ С.БАРХАСМАА



482407007

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН МАЛ ХАМГААЛАХ
САНГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2024.06.18

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Аймгийн засаг даргын баталсан Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын 2024 оны 6 дугаар сарын 10 өдрийн 07 тоот удирдамжаар Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хийж, санхүүгийн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд шалгалтын зорилго оршино.

ХОЁР. ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Шалгалтыг Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2024 оны шалгалтын төлөвлөгөөний дагуу санхүүгийн үйл ажиллагаанд 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 07 тоот удирдамжаар Гурвансайхан сумын Мал хамгаалах сангийн 2024 оны 5 дугаар сарын санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч С.Бархасмаа, Санхүүгийн хяналт шалгалтын байцаагч С.Энхтайван нар хяналт шалгалтыг 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 3 хоногт багтаан хийж гүйцэтгэсэн.

ГУРАВ. ХАМРАГДСАН АСУУДАЛ

Шалгалтыг Гурвансайхан сумын Мал хамгаалах сангийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны холбогдох баримтанд тулгуурлан санхүүгийн үйл ажиллагааг шалгаж үнэлэлт дүгнэлт өгсөн.

Үүнд:

1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл тухайн байгууллагатай холбогдолтой хууль, тогтоомж, дүрэм журам, хамтын гэрээ, үйл ажиллагаандаа мөрдөж буй бусад эрхийн актын хэрэгжилт.
2. 2024 оны 5 сар хүртлэх төсвийн хөрөнгийн захиран зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын байдал.
3. Харилцах болон бэлэн мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хууль эрх зүйн үндэслэл, зарцуулалтын байдал
4. Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн баримтийн бүрдүүлэлт, зарцуулалт тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал
5. Худалдан авах үйл ажиллагаа
6. Өмч хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тооллого, тооцоо бодолт.
7. Өр авлагын барагдуулалт үүссэн өр авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал
8. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилтийг дүгнэсэн байдал
9. Өмнө хийгдсэн шалгалтын зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын тайлан, төлбөр барагдуулалтын байдал
10. Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг үндсэн баримт материалтай нь тулган шалгах.

ДӨРӨВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн хяналт шалгалтаар мал хамгаалах санд зөвлөмж өгөгдөөгүй байна. Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сард гүйцэтгэлийн аудит хийгдэж мал хамгаалах сангийн үйл ажиллагаанд өвс тэжээлийн 4,690.1 мянган төгрөгийн авлага барагдуулах зөвлөмж өгөгдсөн байна.

2023 онд өвс тэжээлийн авлага 100.0 мянган төгрөгийн авлага барагдуулсан.

2024 онд өмнөх оны авлага 270.0 мянган төгрөгөөр буурч ажилласан байна.

Мал хамгаалах сан

Д/Д	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Зөвлөмжийн хэрэгжилт
2	4,690.1 мянган төгрөгийн авлагыг бүртгэл тайланд тусгасан. Авлага барагдуулах зөвлөмж өгөгдсөн	4,690.1 мянган төгрөг	2024 онд өмнөх оны авлага 270,0 мянган төгрөгөөр буурсан байна.

ТАВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Гурвансайхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг хэрэгжүүлэн мал хамгаалах сангийн оролго зарлага хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг гаргаж ажиллана. Мал хамгаалах сангийн үйл ажиллагаа нь “Уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, малчдад учирсан эрсдэлийг бууруулах, байгалийн аюулт үзэгдлийн улмаас малчин, малчин өрх, мал сүрэгт хохирол учруулахаас өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах, бодлогыг баримтлан ажилладаг.

Төсвийн тухай хуулийн 16.4.18-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Мал хамгаалах сангийн 2024 оны санхүүгийн баримтанд дараах албан хаагчид нэг, хоёр дугаар гарын үсэг зурсан байна.

Байгууллагын нэр	Хугацаа	Албан тушаал	Гарын үсэг зурах байдал	Албан хаагчийн нэрс
Мал хамгаалах сан	2020.11.23-наас одоог хүртэл	Сумын Засаг дарга	1 дүгээр сарын үсэг	Э. Адъяабаатар
	2019.04,19-нөөс одоог хүртэл	Нягтлан бодогч	2 дугаар гарын үсэг	Б. Энх- Амгалан

ЗУРГАА: ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 13.1-д байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дотоод хяналт шалгалтын журам тогтоож ажиллана, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 67.1-д төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн

хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 18-р зүйлд нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар заасан заалтын дагуу дотоод хяналтын нэгжийг байгуулж төлөвлөгөө гарган хуулийн заалтуудыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах зөвлөмж өгөгдсөн.

ДОЛОО. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Мал хамгаалах сангийн 2024 оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр:

Мөнгөн хөрөнгийн талаар :

Мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 24,523.2 мянган төгрөг тайлант онд 26,039,5 мянган төгрөгийн авлага орлого орж, өвс тэжээлийн өглөг 7,099.8 мянга, тээврийн хөлсний өглөг 1,800.0 мянган төгрөг нийт 8,899.8 мянган төгрөгийг зарцуулан харилцах дансанд 41,662.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй. Харилцахын үлдэгдэл 17,139.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.

Авлагын тайлангийн талаар :

Мал хамгаалах сангийн авлагын эхний үлдэгдэл 4,692.8 мянган төгрөг, тайлант онд 26,429.6 мянган төгрөгийн авлага үүсэж 26,039,5 мянган төгрөгийн авлага буурч авлагын эцсийн үлдэгдэл 5,082.7 мянган төгрөг байна. 2024 оны эхний авлагын үлдэгдэл 4,692.8 төгрөгийн үлдэгдлээс ЗДТГазрын нярав ажилтай байсан Д.Ренчинбямба 4,500.0 мянга, Б.Түвшинжаргал 103,2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Авлагыг барагдуулах арга хэмжээг зохион байгуулаагүй.

Авлага 390,0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтэй.

Бараа материалын тайлангаар :

Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн эхний үлдэгдэл 23,722.2 мянган төгрөг, худалдаж авсан өвс тэжээл 7,099.8 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан өвс тэжээл 92,535.1 мянган төгрөг, зарцуулсан өвс тэжээл 74,806.1 мянган төгрөг, бараа материалын эцсийн үлдэгдэл 48,551.0 мянган төгрөг байна. Бараа материалын үлдэгдэл 24,828.8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Орлого үр дүнгийн тайлангаар

Тайлант хугацаанд хандив тусламжаар үнэ төлбөргүй ирсэн өвс тэжээл 92,535.1 мянга, малчдаас өвс тэжээлийн авлага 26,429.6 мянган төгрөг нийт 118,964.7 мянган төгрөгийн орлого орсон байна.

Өглөгийн тайлангаар

Өглөг 10,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

НАЙМ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧИЛ

Шалгалтаар :

1. 2024 оны санхүүгийн баримтад өвсний зарцуулалт анхан шатны баримт дутуу, бараа материалын тайлан гараагүй гараагүй, үлдэгдэл баталгаажаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдлөгө болгон ажиллаагүй.

АРАВ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Шалгалтын удирдамжийг Төсвийн ерөнхийлөн захирагч, удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад танилцуулж, шалгалтыг холбогдох нягтлан бодогч нарыг

байлцуулан үндсэн баримтанд тулгуурлан явуулж, зөрчилтэй зүйлүүдэд тухай бүр нь хуулийн заалтын үндэслэн тайлбарлан, нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийг залруулах, няравт анхан шатны баримтыг хэрхэн бүрдүүлэх, хэрэглэх талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ.

АРВАН НЭГ. ШАЛГАЛТААР ӨГСӨН ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулан байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн, санхүүгийн программ ашиглан нягтлан бодох бүртгэлийг хөтөлж хууль тогтоомж, УСНББОУСтандартыг мөрдөн ажилласан байна.

АРВАН ХОЁР. ШАЛГАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ

1. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг мал хамгаалах сангийн үйл ажиллагаанд чиглүүлэх, муудсан эрсдэлтэй ашиглах боломжгүй гэж үзсэн 6 төрлийн 273 тоо ширхэг 3,552.4 мянган төгрөгийн өвс тэжээлийг тооллогын комиссоор баталгаажуулан, өмч хамгаалах зөвлөлөөр шийдвэрлүүлэх, устгалтын акт үйлдэж устгах.
2. Бараа материалын тайланг сар бүр гаргаж нягтлан бодогчоор тооцоогоо бодуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" /20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ гэсэн заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.
3. Авлага дансны тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлага бууруулах ажлыг зохион байгуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 07 дугаар сарын 25-ний дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр, нотлох баримтын хамт хариу ирүүлэх.

ТАЙЛАН:

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ С.БАРХАСМАА

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ
С.ЭНХТАЙВАН

ТАНИЛЦСАН:
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Э.АДЪЯАБААТАР


СУМЫН САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА
Д.БАЯРЦЭНГЭЛ
НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЭНХ-АМГАЛАН
СУМЫН ЗДТГ-ЫН НЯРАВ

Д.ЭРДЭНЭБАЯР

Удирдлагаас авах ерөнхий асуулга

Байгууллагын нэр	Гурвансайхан сум ЗДТГ
Асуулгад хариулсан	Тамгын газрын дарга Б.Энхтуяа
Асуулга авсан	Дотоод аудитор Б.Батсайхан
Огноо	2024 оны 6 сарын 17-ны өдөр
Байгууллагын үндсэн мэдээлэл	
1. Байгуулагдсан огноо, шийдвэрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэгдсэн регистрийн дугаар	2001 оны 09 сарын 28 нд СИТХ-ын 01 тоот тогтоолоор байгуулагдсан. Регистр 9033645
2. Байгууллагын нэр, хаяг, утас, цахим хуудас	ЗДТГ Гурвансайхан 5-р баг Суугаант, Төв-4 401 тоот 70596425 gurvansaikhan@dundgovi.gov.mn
3. Өмчийн хэлбэр	Төрийн
4. Ажиллагсдын тоо	19
5. Жилийн төсөв	831.9
6. Харъяа байгууллагын тоо	-
7. Удирлагын нэр, албан тушаал, томилогдсон огноо.	Засаг дарга Э.Адъяабаатар
8. Удирдлагын ажлаа тайлагнадаг ТЕЗ / эсвэл ТУЗ/-ийн нэр	Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат
Байгууллагын талаар ойлголт олж авах:	
1. Байгууллагын стратеги, зорилго зорилт. Орон нутгаа хөгжүүлэх, оновчтой бодлогыг хэрэгжүүлдэг, манлайлагч хамт олон байна.	
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тасралтгүй нэмэгдүүлэх - Албан хаагчийн хариуцлага, чадамжийг нэмэгдүүлэх - Эвсэг хамт олон байх	
2. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа. Төрийн үйлчилгээ	
3. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг гол хууль тогтоомж, бодлого, дүрэм, журам Төсвийн тухай хууль, төрийн албан тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам", "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"	
4. Байгууллагын засаглалын бүтэц Засаглах удирдлага Аймгийн ТЕЗахирагч Гүйцэтгэх удирдлага Сумын ТЕЗахирагч Дотоод аудит ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	
5. Байгууллагын эрсдлээ тодорхойлж, үнэлдэг үү. Бууруулах талаар ямар арга хэмжээ авдаг бэ Эрсдэл тооцож үнэлсэн сүүлийн 3 жил	
6. Байгууллагын дотоод хяналтаа хэрхэн хэрэгжүүлдэг бэ. Стандартын хүрээнд	
7. Байгууллагад тулгамдаж байгаа ямар эрсдэлтэй асуудал байгаа бэ Боловсон хүчин, удирдлагын манлайлал	
8. Дотоод аудитыг ямар асуудалд илүү анхаарал хандуулахыг хүсэж байна бэ Санхүү төсөвийн тал дээр, хандивийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил дээр хяналт хийх	

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:  Б.Энхтуяа/Асуулга авсан:  Б.Батсайхан/

Байгууллагын засаглалын талаар нарийвчилсан асуулга, аудиторын дүгнэлт

Байгууллагын нэр	Гурвансайхан сумын ЗДТГ
Асуулгад хариулсан	Тамгын газрын дарга Б.Энхтуяа
Асуулга авсан	Дотоод аудитор Б.Батсайхан
Огноо	2024 оны 6 сарын 17-ны өдөр

Засаглах удирлагын талаархи мэдээлэл	
1. Засаглах удирлагын нэр	Гурвансайхан Сумын засаг дарга
2. Засаглах удирдлагын эрх ба үүрэг	1. Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх; 2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх; 3. Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх; 4. Сумын төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах; 5. Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх; гэх мэт
3. ТУЗ-ийн гишүүд	-
ТУЗ-ийн төсөв	-

Засаглах удирлагын оролцооны талаар	
1. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг тодорхойлоход оролцдог эсэх Стандартын хүрээнд хийгддэг болхоор оролцдоггүй	
2. Байгууллага эрсдлээ хэрхэн удирдаж байгаад, мөн эрсдлийг бууруулахад чиглэсэн дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьдаг эсэх Төлөвлөгөөнд тусган, иргэд рүү хандан цахимаар болон цаасаар санал авч хэрэгжүүлдэг	
3. Байгууллагын дотоод ёс зүй, үнэт зүйлсийг үнэлж, дэмждэг эсэх Үнэлж дүгнэдэг, ёс зүйн талаар төрийн албан хаагчдтай гэрээ хийж 2022, 2023 онд зөрчил гаргасан 2 албан хаагчийг чөлөөлсөн	
4. Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнтэй байдлыг үнэлж, хариуцлага тооцдог эсэх Хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлдэг	
Бусад холбоотой асуудал	
1. Засаглах удирдлага ба гүйцэтгэх удирдлагын хооронд түвшинд эрсдэл, хяналтын талаар мэдээлэл солилцдог эсэх Тухай бүрт мэдээлэл солилцдог	
2. Хөндлөнгийн ба дотоод аудит, бусад хяналтын байгууллагуудын хооронд, эсвэл эдгээр байгууллагууд болон засаглах удирлага, гүйцэтгэх удирдлагын хооронд хангалттай, үр дүнтэй харилцаа байгаа юу Хяналт шинжилгээ үнэлгээтэй тогтмол харилцаатай	
3. Байгууллагын засаглалтай холбоотой ямар эрсдэлүүд байна бэ Дэмжлэг хамтын ажиллагааг сайжруулах.	

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:/Б.Энхтуяа/

Асуулга авсан:/Б.Батсайхан/



Байгууллагын эрсдлийн удирдлагын талаар нарийвчилсан асуулга, аудиторын дүгнэлт

Байгууллагын нэр	Гурвансайхан ЗДТГ
Асуулгад хариулсан	Тамгын газрын дарга Б.Энхтуяа
Асуулга авсан	Дотоод аудитор Б.Батсайхан
Огноо	2024 оны 6 сарын 17-ны өдөр

Байгууллагын эрсдлийн удирдлагын талаар мэдээлэл	
1. Эрсдлийн удирдлагын бодлого журамтай эсэх Эрсдлийн үнэлгээ хийгдсэн – ГС-ЧТМ -08-01 баримтаар баталгаажуулсан	
2. Эрсдлийн удирдлагын тусдаа газар нэгжтэй эсэх багуудтай	
3. Үйл ажиллагаа энгийн эсвэл нарийн төвөгтэй эсэх Энгийн	
4. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хангахад ямар эрсдлүүд одоо тулгарч байгаа эсвэл цаашид бий болохоор байна бэ? Боловсон хүчин, төсөв санхүү	
5. Гол эрсдлийг бүртгэж, үнэлж, албажуулдаг уу? Бүх үйл ажиллагаан дээр эрсдэлийг тодорхойлж албажуулсан.	
6. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг хангахад сөргөөр нөлөөлөх гол эрсдлийг бууруулах, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авдаг бэ? Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажилладаг.	
7. Байгууллагад тулгарч байгаа эрсдлийн талаар засаглах удирдлага болон байгууллагын бусад нэгж, ажилтнуудад мэдээлдэг үү? Байгууллагын эрсдэлийн болон тулгамдаж байгаа асуудал ажлын хариуцлага алдагдаж байгаа талаар удирдлага болон албан хаагчдад танилцуулан ажилладаг.	
8. Тулгарч байгаа эрсдэл нь “эрсдлийн дуршил /аппетит/-аас доош хэмжээнд байгаа эсэхийг үнэлдэг үү? үгүй	
9. Байгууллагад тулгамдаж байгаа мэдээллийн технологитой холбоотой эрсдэлтэй асуудал байгаа юу ? Мэдээлэл технологийн мэргэжил-ийн ажилтан байхгүй,	
10. Байгууллагад тулгамдаж байгаа залилангийн эрсдэлтэй асуудал байгаа юу? Байхгүй	
11. Байгууллага залилангийн эрсдэлээс сэргийлэхний тулд ямар арга хэмжээ авдаг вэ? Энэ талаар хийсэн судалгаа арга хэмжээ байхгүй	
12. Дотоод аудитаар эрсдлийн удирдлагын ямар асуудалд илүү анхаарал хандуулахыг хүсч байна вэ? Төсөв мөнгөтэй холбоотой мэдээлэл солилцох, тайлан	
Байгууллагын эрсдлийн удирдлагын талаар аудиторын дүгнэх хэсэг	
1. Байгууллагын эрсдлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээ	
Эрсдлийн дуршил /аппетит/-г тодорхойлж ашиглах	2-р түвшин буюу давтамжтай. (Байгууллагын хэмжээнд эрсдэлийн аппетитийг тогтоогоогүй
Эрсдлийн үнэлгээ хийх	3-р түвшин буюу томъёолсон. (2022 онд мэргэжлийн байгууллагаар 3 ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн. Гүйцэтгэх удирдлага уг үнэлгээнд суурилан, авах арга хэмжээг төлөвлөсөн. Эрсдэлийн үнэлгээ нь байгууллагын стратеги, зорилго, зорилттой уялдсан.

Эрсдлийн талаар нэгдсэн ойлголт, чиг хандлага	3-р түвшин буюу томъёолсон. (Эрсдэлийн талаар ойлголт байгууллагын хэмжээнд тогтсон, нэгдсэн ойлголтод хүрсэн, төрөл бүрийн эрсдэлийн бүртгэл болон эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд ашигладаг)
Эрсдлийн мэдээллийг ашиглах	4-р түвшин буюу удирдсан. (Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн)
Тодорхойлсон эрсдлийг хэрхэн удирдаж байгаад дүн шинжилгээ хийх	2-р түвшин буюу давтамжтай. (Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн гүйцэтгэх удирдлагын тушаал гаргаж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталсан, хэрэгжүүлэх ажил хийгдэж эхэлсэн)
Эрсдлийг үнэлэх явцдаа залилан байгаа эсэхийг харгалзан үздэг эсэх	1-р түвшин буюу эхлэлийн. (Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийхэд залилангийн эрсдэлийг харгалзан үзээгүй)
Эрсдлийн удирдлагын дотоод хяналтын системд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж үнэлэх	1-р түвшин буюу эхлэлийн. (Эрсдэлийн удирдлагын дотоод хяналтын системд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоогүй)
1. Байгууллагын эрсдлийн удирдлагатай холбоотой одоо мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байна уу? ХАБЭА-н тухай хуулийг хэрэгжүүлж ажилладаг. 2. Байгууллагын эрсдлийн удирдлага нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бенчмарк жишиг /COSO, ISO гэх мэт/-тэй нийцэнж байна уу? Хэсэгчлэн	

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:  /Б.Энхтуяа/
Асуулга авсан:  /Б.Батсайхан/



Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар нарийвчилсан асуулга ба аудиторын дүгнэлт

Байгууллагын нэр	Гурвансайхан сумын ЗДТГ
Асуулгад хариулсан	Тамгын газрын дарга Б.Энхтуяа
Асуулга авсан	Дотоод аудитор Б.Батсайхан
Огноо	2024 оны 6 сарын 17- ны өдөр

Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл			
1. Дотоод хяналтын бодлого журамтай эсэх Журамтай			
2. Дотоод хяналтын тусдаа газар нэгжтэй эсэх Хяналт шалгалтын багтай			
3. Байгууллагын долтоод хяналтын орчинг бүрдүүлж байгаа дараах элементүүдийг хэрхэн баримтжуулсан бэ?			
Үндсэн элементүүд	Тийм	Үгүй	Холбогдох баримт бичгийн нэр
Шударга байдал ёс зүйн үнэт зүйлс	+		Стратеги төлөвлөгөө, Хөдөлмөрийн дотоод журамд Ёс зүйн журмыг оруулсан.
Удирдлагын хандлага, ур чадвар, арга барил	+		албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад тодорхой тусгасан. Удирдлагын тушаал шийдвэрийн үндэслэлээ зөв тодорхойлсон байдал.
Зохион байгуулалтын бүтэц	+		Захирамжаар бүтэц орон тоо, цалинг тогтоосон.
Эрх мэдэл, үүрэг хариуцлагын хуваарилалт	+		Ажиллагсдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан.
Хүний нөөцийн бодлого, боловсон хүчний ур чадвар	+		Стратеги төлөвлөгөө, байгууллагын хүний нөөцийн бодлогын журам, сургалтын хөтөлбөрт тусгагдсан.
4. Байгууллагад бодитойгоор хэрэгжиж байгаа “урьдчилан сэргийлэх хяналт”-ыг нэрлэнэ үү. Эдгээрээс аль нь гол хяналт вэ? Гадна дотор камер			
5. Байгууллагад бодитойгоор хэрэгжиж байгаа “илрүүлэх хяналт”-ыг нэрлэнэ үү? Эдгээрээс аль нь гол хяналт бэ? Камер			
6. Байгууллагад бодитойгоор хэрэгжиж байгаа “гараар хийгддэг хяналт” эсвэл “автоматаар/ системээр хэрэгждэг хяналт”-ыг нэрлэнэ үү? Эдгээрээс аль нь гол хяналт бэ? Албан хаагчдийн эд хөрөнгийн тооллого			
7. Байгууллагад бодитойгоор хэрэгжиж байгаа “хамгийн олон давтамжтай хийгддэг хяналт”-ыг нэрлэнэүү? Эдгээрээс аль нь гол хяналт бэ? Бичиг хэргийн хяналт			
8. Дотоод аудитаар дотоод хяналтын системийн талаар ямар асуудалд илүү анхаарал хандуулахыг хүсч байна вэ? Төрийн байгууллагын цахим бүртгэлийн ашиглалт.			
Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар аудиторын дүгнэх хэсэг			
1. Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийн үнэлгээ			
Дотоод хяналтын орчин			
Шударга байдал, ёс зүйн үнэлэмжийг тогтоох	3-р түвшин буюу томъёолсон. (Шударга байдал, ёс зүйн үнэлэмжийг журмаар тодорхой, ойлгомжтой тусгасан)		
Засаглах удирдлага нь гүйцэтгэх удирдлагаас хараат бус байх, дотоод хяналтыг бүрдүүлэх, хэрэгжүүлэхэд хяналт тавих	3-р түвшин буюу томъёолсон. (Засаглах удирдлагаас гүйцэтгэх удирдлагад хяналт тавих үйл ажиллагаа хийгддэг)		

Байгууллагын зорилготой уялдуулан гүйцэтгэх удирлага байгууллагын бүтэц, тайлагнах үе шат, эрх мэдэл ба хариуцлагыг тодорхойлох	3-р түвшин буюу томьёолсон. (Байгууллагын бүтэц, тайлагнах үе шат, эрх мэдэл ба хариуцлагын журамтай, зорилготой уялдсан)
Чадвартай ажилтан авах, хөгжүүлэх болон хадгалахад чиглэсэн хүний нөөцийн бодлоготой байх	3-р түвшин буюу томьёолсон. (Байгууллагын стратеги зорилго хүний нөөцийн бодлоготой уялдсан)
Ажилтан бүр дотоод хяналтын үүрэг хариуцлагыг хүлээдэг байх	3-р түвшин буюу томьёолсон. (Ажилтны үүрэг хариуцлагыг байгууллагын стратеги, зорилготой уялдуулсан)
Хяналтын үйл ажиллагаа	
Эрсдлийг “Эрсдлийн аппетит” / хүлээн зөвшөөрөх түвшин/хүртэл бууруулахад чиглэсэн хяналтын үйл ажиллагааг тодорхойлох	3-р түвшин буюу томьёолсон. (Байгууллагын дотоод хяналтын комиссын үйл ажиллагаа боломжийн)
Мэдээллийн технологид ерөнхий хяналтуудыг хэрэгжүүлэх	3-р түвшин буюу томьёолсон. (Мэдээллийн технологид дотоод хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлдэг)
Дотоод хяналтын үйл ажиллагааг бодлого, журамд тусгах замаар хэрэгжүүлэх	3-р түвшин буюу томьёолсон. (Байгууллагын түвшинд хэрэгжүүлэх дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлсон)
Мэдээлэл дамжуулалт ба харилцаа	
Дотоод хяналтын чиг үүргийг дэмжихүйц чанартай мэдээллийг олж авч, ашигладаг байх.	3-р түвшин буюу томьёолсон. (Холбогдох мэдээлэлийг ашигладаг)
Дотоод хяналтын мэдээллийг дотооддоо дамжуулдаг байх	3-р түвшин буюу томьёолсон. (Засаглах болон гүйцэтгэх удирдлагын хооронд дотоод хяналтын үйл ажиллагааны талаар тухай мэдээлэл солилцдог)
Дотоод хяналтын чиг үүрэгт нөлөөлөх асуудлуудын талаар гадаад талуудтай харилцах	3-р түвшин буюу томьёолсон. (Дотоод хяналтын чиг үүргийн талаар гадаад талуудтай үр дүнтэй харилцаатай)
Мониторинг	
Дотоод хяналтын үйл ажиллагаанд байнгын эсвэл тусдаа үнэлгээ хийх	3-р түвшин буюу томьёолсон. (Дотоод хяналтын үйл ажиллагааг шалгаж, үнэлдэг)
Засаглах ба гүйцэтгэх удирдлагад дотоод хяналтын үйл ажиллагааны сул талыг мэдээлэх	3-р түвшин буюу томьёолсон. (засаглах удирдлагад мэдээлж хэвшсэн)
2. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоотой холбоотой одоо мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байна уу	Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажилласан.
3. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бенчмарк жишиг /COSO, ISO гэх мэт/-тэй нийцэж байна уу	тийм

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:  /Б.Энхтуяа/

Асуулга авсан:  /Б.Батсайхан/



ЭРСДЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

№	Учирч болох эрсдлүүд	Тохиолдох магадлал	Нөлөөлөл	Үнэлгээ
1	Байгууллагын төсвийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх, үр дүн буурах	1	1	1

БАТЛАВ. Санхүүгийн хяналт дотоод

аудитын албаны дарга /С.Бархасмаа/

2024 оны 6 сарын 17 өдөр

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТУЗ 962 А 3432823

Аудитын объект: Дундговь аймаг Гурвансайхан сумын ЗДТГ

Аудитын ажлын зорилго.

Гурвансайхан сумын ЗДТГ, Тусгай сангуудын засаглал, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

Аудитын хамрах хүрээ:

- Байгууллагын засаглал, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх
- 2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Хязгаарлалтгүй

Аудитад хамрагдах тайлант хугацаа: 2024.06.16-2024.06.19

Аудитын ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө:

№	Үйл ажиллагааны агуулга	Хэрэгжүүлж эхлэх дуусах хугацаа		Хариуцах ажилтан
1	Аудитын объектын мэдээлэл цуглуулах	VI/16	VI/18	Б.Батсайхан
2	Засаглал, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авах, холбогдох бичиг баримттай танилцах, төлөвшлийг тодорхойлох	VI/16	VI/18	Б.Батсайхан
3	Эрсдлийн урьдчилсан үнэлгээ	VI/17	VI/17	Б.Батсайхан
4	Илэрсэн асуудлын нэгтгэл гаргаж, байгууллагын удирдлагатай хэлэлцэх	VI/17	VI/18	Б.Батсайхан
5	Аудитын тайлан бэлтгэх	VI/17	VI/18	Б.Батсайхан
6	Аудитын тайланг удирдлагад танилцуулах уулзалт хийх	VI/18	VI/19	Б.Батсайхан

Боловсруулсан: Б.Батсайхан

Хянасан: С.Бархасмаа

ДОТООД АУДИТАД ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Аудитын объект

Дотоод аудитын баг нь байгууллагын удирдлагатай 2024 оны 6 сарын 18 –нд уулзалт хийхээр товлож байна. Иймд уулзалтаас өмнө доорхи бичиг баримтуудыг урьдчилан бэлтгэж, аудитын багт бүрэн гаргаж өгөхийг хүсэж байна.

№	Бичиг баримтын нэр	Гаргаж өгөх хугацаа	Хүлээн авсан эсэх	Бичиг баримтаар хангасан ажилтан	Бичиг баримтыг хүлээн авсан аудитын ажилтан
1	Байгууллагын гэрчилгээ, дотоод журам	VI/17	Тийм	Т.Хүдэрчулуун	С.Бархасмаа
3	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт	VI/17	Тийм	Т.Хүдэрчулуун	С.Бархасмаа
4	ЗДТГ-ын 2024 оны харилцахын баримт	VI/17	Тийм	Т.Хүдэрчулуун	С.Бархасмаа
5	ОНХС-ийн 2024 оны ИТХ-ын төсөв баталсан тогтоол	VI/17	Тийм	Б.Энх-амгалан	Б.Батсайхан
4	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний иргэдийн санал нэгтгэл, эрмбэлсэн жагсаалт, зураг төсөв, ТЭЗҮ, тооцоо	VI/17	Тийм	Б.Энх-амгалан	Б.Батсайхан
5	Хоршоо хөгжүүлэх сангийн баримт материал	VI/17	Тийм	Б.Энх-амгалан	С.Бархасмаа
6	Байгаль хамгаарах сангийн харилцахын баримт, бусад материал	VI/17	Тийм	Б.Энх-амгалан	Б.Батсайхан
7	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан эсэх түүнтэй холбоотой баримт	VI/17	Тийм	Б.Энх-амгалан	С.Бархасмаа

Боловсруулсан:


Б.Батсайхан

Хянасан:

С.Бархасмаа



УРСГАЛ ДИАГРАМ



R – тухайн үйл явц эсвэл үйл ажиллагаанд учирч байгаа эрсдэл

C – Тухайн эрсдлийн хариуд удирдлагаас хэрэгжүүлж байгаа дотоод хяналт

ЭРСДЭЛ ХЯНАЛТЫН МАТРИЦ

Үе шат	Эрсдлийн дугаар	Эрсдлийн агуулга	Үүсэх магадлал	нөлөөлөл	Эрсдлийн үнэлгээ	Хяналтын дугаар	хяналт	давтамж	Гол хяналт
Сумын болон байгууллагын дарга, захирал, нягтлан бодогч	R1	Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх	1	3	3	C1	Төсвийн хууль тухай	3	Тийм
	R2	Баталгаажсан өр төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах	1	3	3	C2	Нягтлан бүртгэлийн хууль бодох тухай	3	Тийм

Хяналт бодитойгоор байгаа эсэх		Хяналт үр нөлөөтэй эсэх						Хяналтын үнэлгээ (Хүчтэй, сул, муу)	Илэрсэн асуудлын нэгтгэлд оруулах эсэх
Хяналт бодитойгоор хэрэгжиж байгааг дурдах	хэрхэн	Тийм эсвэл үгүй	Сорил хийх баримт бичгийн нэр	Сорилд хамрагдсан түүврийн тоо	Түүвэрлэсэн арга	Сорилгоор илэрсэн алдааны утга	Сорилгоор илэрсэн алдааны утга		
Дотоод хяналт шалгалт хийгдээгүй		Үгүй	Санхгийн тайлан	1 Байгууллага 2 албан хаагч	Санамсаргүй	1	Ажил зохион байгуулаагүй	Муу	Тийм

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 3000

ИЛЭРСЭН АСУУДЛЫН НЭГТГЭЛ

Асуудлын утга	Холбогдох ажлын баримтын дугаар	Асуудлын ангилал /нөлөөтэй эсэх/	Нөлөөлөх хууль тогтоомж дүрэм, журам	Аудитын тайланд оруулах эсэх
Өглөг, авлага барагдуусах ажил зохион байгуулаагүй	АБ2003	Тийм	Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Тийм

ҮНДСЭН ШАЛТГААНЫ ШИНЖИЛГЭЭ

Илэрсэн асуудлын утга	Бодит нөхцөл байдал /ямар байна бэ/	Шалгуур /ямар байх ёстой бэ/	Үндсэн шалтгаан /5 яагаад арга эсвэл загасан нуруу арга ашиглах/
2023 оноос хойших өр, авлагыг барагдуулаагүй	1. 2023 онд С.Өлзий-эрдэнийг ажлаас чөлөөлсөн буруутай шийдвэрийн улмаас 1,794.5 мянга, 2024 онд 1,650.0 мянга нийт 3,444.5 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр байгууллагын төсвөөс шилжүүлсэн, төрд учирсан хохирлыг авлагаар тусгасан боловч барагдуулаагүй. 2. 2023 онд үүссэн Б.Өлзийжаргалтай холбогдох байрны түрээсийн авлага болох 343.3 мянган төгрөгийг барагдуулаагүй. 3. 2023 оны сумын ерөнхий боловсролын сургуулийн цэвэр бохир усны хэрэглээний төлбөр болох 2,343.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй. 4. 2023 онд бараа худалдан авах гэрээ байгуулан шилжүүлсэн "Туулант гол" ХХК-аас авах 738.0 мянга, Онцгой өргөө ХХК-наас 1,500.0 мянган төгрөгийн бараа нийлүүлэгдээгүй, авлага барагдаагүй гэрээний үүрэг биелэгдээгүй байна 5. Хувь хүмүүс, айл өрхүүдээс авах цэвэр бохир усны төлбөр болох 1,444.0 мянга, Төрд учруулсан хохирол болох Д.Төмөртогтохоос 7,169.6 мянга, нярав хийж байсан У.Баярсайханаас 195.8 мянга, иргэн И.Энэбишээс авах 2,000.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй. 2023 оны түлш халаалтын өглөг болох 9,787.1 мянган төгрөгийг төлөөгүй.	1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;	1. 2023 онд яагаад өр, авлагатай ажилласан бэ. - Төсвийн мөнгө хүрээгүй, түлш халаалтын тариф өөрчлөгдсөн 2. Түрээсийн авлага яагаад барагдахгүй байна вэ - Түрээслэгч шилжсэн учраас авлагаа авч чадаагүй 3. Хувь хүмүүс, айл өрхүүдээс авах цэвэр бохир усны төлбөр болох 1,444.0 мянга төгрөгийн авдага яагаад барагдахгүй байна вэ. - Хувь хүмүүстэй тооцоо нийлсэн боловч өгөхгүй байгаа 4. Яагаад авлага барагдуулах ажил зохион байгуулахгүй байна вэ. - Уг нь хэл ярьдаг хүмүүс нь өгөхгүй юм. 5. Үндсэн шалтгаан: Өр авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй хөөцөлдөлгөө байхгүй байна.

Аудит хийгдсэн байгууллага:

Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, байгаль хамгаалах сан

Огноо: 2024.06.17

ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ДУНДГОВЬ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа.

Жил: 2024

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 4000

АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: ДУНДГОВЬ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗДТГ, ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САН, ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН, БАЙГАВЬ

АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА: 2024.06.16 – 2024.06.18

Дотоод аудитын нэгжийн дарга: С.Бархасмаа

Аудитын багийн ахлагч: С.Бархасмаа

Аудитын багийн гишүүд: Б.Батсайхан

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1. Аудитын зорилго
 - 2.2. Аудитын цар хүрээ
3. Байгууллагын сайн туршлага
 - 3.1. Засаглалын удирдлагын талаар
 - 3.2. Эрсдлийн удирдлагын талаар
 - 3.3. Дотоод хяналтын талаар
4. АУДИТЫН ҮР ДҮН
 - 4.1. Илэрсэн асуудлууд
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. ТАНИЛЦУУЛГА

Дундговь аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2024 оны дотоод аудитын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын баталсан № 02 тоот удирдамжийн дагуу 2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго.

Гурвансайхан сумын ЗДТГ, тусгай сангуудын засаглал, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.

Дотоод аудитад ЗДТГ, тусгай сангийн засаглал, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын явц, 2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга аргачлал

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтанд дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн хяналт шалтгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТХууль
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"
- "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"
- "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"
- Монгол улсын Засгийн газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Тус сум 2022 оны 01 сараас ISO- 9001-2015 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба 2015 онд иргэдийн оролцоотой улсын хэмжээний жишиг сум, 2019 алтан гадас одонт сум болон ажилласан сайн туршлагатай байна.

3.1 Засаглалын талаар

Засаг даргын тамгын газар нь “Ёс зүй, үнэт зүйлс, хүний нөөцийн хариуцлагын тогтолцоо, хяналт шинжилгээ үнэлгээ-мониторинг, тайлагналын ил тод байдал” гэсэн асуудлаар засаглалын түвшинд үнэлгээ хийсэн.

2021-2024 он хүртэл байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Байгууллагын стратеги зорилго, зорилт үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан гаргасан.

Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаа тусгай сангийн үйл ажиллагаад нэг дүгээр гарыг үсгийг Сумын засаг дарга, тамгын газрын дарга, хоёр дугаар гарын үсгийг сангууд хариуцсан нягтлан бодогч нар зурж хөрөнгийг захиран зарцуулдаг.

3.2 Эрсдэлийн удирдлагын талаар

Тус сумын Засаг даргын тамгын газар нь эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай ГС-ЧМТ-09 стандартаар баталгаажуулсан байна. Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт чиг хандлага, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрт байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж, үнэлүүлсэн байна.

Сумын засаг даргын 2024 оны 5 сарын 08-ны өдрийн А/40 дугаар захирамжаар “Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймэрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулан ажиллаж байна

3.3 Дотоод хяналтын системийн талаар

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 18-р зүйлд нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" ын дагуу дотоод хяналтын нэгж байгуулан хяналт шалгалтын төлөвлөгөө гарган ажилласан байна. Төлөвлөгөөний дагуу удирдамж батлуулан шалгалтыг зохион байгуулж ажилсан байна.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Гурвансайхан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр:

Орон нутгийн төсвийн орлогын талаар:

Татварын орлого 2024 онд 1,418,365.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Эхний 5 сарын байдлаар татварын орлогод 497,641.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 635,743.1 мянган төгрөгийг төвлөрүүлж 138,101.3 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан үзүүлэлттэй байна.

Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл эхний 05 сарын байдлаар дараах байдалтай байна.

код	Татварын орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
110001	Цалин, түүнтэй адилтгах орлого	347,300.0	414,553.8	(67,253.8)	119
110002	Үйл ажиллагааны орлого	21,780.0	68,736.9	(46,956.9)	316
110004	Хөрөнгө борлуулсны орлого	9,560.0	18,324.3	(8,764.3)	192
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	7,450.0	29,346.1	(21,896.1)	394
113002	Бууны албан татвар	420.0	360.0	60.0	86

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 4000

113004	Малд ногдуулах албан татвар	35,000.0	14,611.0	20,389.0	42
118001	Улсын тэмдэгтийн хураамж	800.0	2,076.5	(1,276.5)	260
118006	Түгээмэл тархацтай АМАТ	200.0	-	200.0	0
118009	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	1,800.0	10,350.0	(8,550.0)	575
118101	Газрын төлбөр	70,681.8	67,644.0	3,037.8	96
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-	
118304	Бусад орлого	-	-	-	
120002	Хүүгийн орлого	-		-	100
120003	Торгуулийн орлого	2,650.00	9,740.50	(7,090.5)	368
		497,641.8	635,743.1	(138,101.3)	127.8

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Засаг даргын тамгын газар:

2024 оны 5 дугаар сарын эхэнд харилцах дансны эхний үлдэгдэлгүй, 376,358.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 292,891.7 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 83,466.9 мянган төгрөгний харилцахын үлдэгдэлтэй. Тайлант хугацаанд 23,140.1 мянган төгрөгийн авлагатай, 17,656.3 мянган төгрөгийн өглөгтэйгээр тайлагнасан байна.

Хоршоо хөгжүүлэх сан:

2024 оны 05 дугаар сард харилцах дансны эхний үлдэгдэл 58,504.2 мянган төгрөг, зээл зээлийн хүүгийн орлого 22,741.0 мянган төгрөг оруулж, үйл ажиллагааны зардал буюу программын төлбөрт 150.0 мянган төгрөг зарцуулж, 81,095.2 мянган төгрөгний харилцахын үлдэгдэлтэй. Тайлант хугацаанд 152,355.5 мянган төгрөгний зээл зээлийн хүүгийн авлагатай, 150.9 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулсан.

2024 онд зээл олгоогүй.

Байгаль хамгаалах сан:

2024 оны 05 дугаар сард харилцах дансны эхний үлдэгдэл 87,540.9 мянган төгрөг, орлого 1,750.0 мянган төгрөг оруулж, үйл ажиллагааны зардал 2,647.2 мянган төгрөг зарцуулж, 100,712.4 мянган төгрөгний харилцахын үлдэгдэлтэй. Тайлант хугацаанд авлаггүй, 767.0 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн жагсаалтыг батлуулж наадмын талбан тохижилтын ажилын тендер шалгаруулалтын ажил хийгдэж байна.

Д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
1.	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ		409,264,200	409,264,200
1.1	Сумын төвийн цэвэрлэх байгууламж шинээр барих	2023-2024	409,264,200	409,264,200
2.	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	2024	1,512,531,700	1,512,531,700

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ 4000

2.1	Сумын төвийн цэвэрлэх байгууламж шинээр барих	2024	540,735,800	540,735,800
2.2	Төрийн албан хаагчдын байр шинээр барих	2024	680,000,000	680,000,000
2.3	Наадмын талбайн тохижилт, засвар	2024	180,000,000	180,000,000
2.4	Хүүхдийн тоглоомын талбайг нэмэлтээр тохижуулах	2024	19,500,000	19,500,000
2.5	Сумын төвийн засмал замыг сэргээн засварлах	2024	15,000,000	17,795,900
2.6	Гэрэлтүүлэг, камержуулалт	2024	19,000,000	19,000,000
2.7	Зураг төсвийн зардал	2024	55,500,000	55,500,000
3.	Малын тоо толгойн албан татвар	2024	256,508,400	256,508,400
3.1	Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	2024	128,042,900	128,042,900
3.2	Малчдад зориулсан сургалт, суртчилгаа	2024	20,000,000	20,000,000
3.3	Усан хангамж нэмэгдүүлэх	2024	80,000,000	80,000,000
3.4	Халдварт өвчинөөс сэргийлэх	2024	5,000,000	5,000,000
3.5	Гэмт халдлага, гамшигаас хамгаалах	2024	6,000,000	6,000,000
3.6	Байгаль орчин хамгаалах, Оготно устгал	2024	17,465,500	17,465,500
4.	ОНХС-аас санхүүжих суурь зардал		2,178,304,300	2,178,304,300
4.1	2023 оны үлдэгдэл		409,264,200	409,264,200
4.2	2023 оны малын тоо толгойн албан татварын үлдэгдэл		103,655,242	103,655,242
4.3	2024 оны санхүүжилт		1,512,531,700	1,512,531,700
4.4	2024 оны малын тоо толгойн албан татвар ногдуулалт		122,675,400	122,675,400
4.5	2023 оны орон нутгийн орлогын /МТТАТ/ үлдэгдэлээс санхүүжих		30,177,700	30,177,700
	Нийт дүн		2,178,304,300	2,178,304,300

5. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1.	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 9,787.1 мянган төгрөгийн өр, 19,178.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй.
Асуудлын ангилал	Нөлөөл ихтэй
Бодит байдал:	

1. 2023 онд С.Өлзий-эрдэнийг ажлаас чөлөөлсөн буруутай шийдвэрийн улмаас 1,794.5 мянга, 2024 онд 1,650.0 мянга нийт 3,444.5 мянган төгрөгийг шүүхийн шийдвэрээр байгууллагын төсвөөс шилжүүлсэн, төрд учирсан хохирлыг авлагаар тусгасан боловч барагдуулаагүй.
2. 2023 онд үүссэн Б.Өлзийжаргалтай холбогдох байрны түрээсийн авлага болох 343.3 мянган төгрөгийг барагдуулаагүй.
3. 2023 оны сумын ерөнхий боловсролын сургуулийн цэвэр бохир усны хэрэглээний төлбөр болох 2,343.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй.
4. 2023 онд бараа худалдан авах гэрээ байгуулан шилжүүлсэн "Туулант гол" ХХК-аас авах 738.0 мянга, Онцгой өргөө ХХК-наас 1,500.0 мянган төгрөгийн бараа нийлүүлэгдээгүй, авлага барагдаагүй гэрээний үүрэг биелэгдээгүй байна
5. Хувь хүмүүс, айл өрхүүдээс авах цэвэр бохир усны төлбөр болох 1,444.0 мянга, Төрд учруулсан хохирол болох Д.Төмөртогтохоос 7,169.6 мянга, нярав хийж байсан У.Баярсайханаас 195.8 мянга, иргэн И.Энэбишээс авах 2,000.0 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй.
6. 2023 оны түлш халаалтын өглөг болох 9,787.1 мянган төгрөгийг төлөөгүй.

Байх ёстой шаардлага / шалгуур/

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

Асуудлын үндсэн шалтгаан:

- Өр авлага үүсгэж, барагдуулах ажил зохион байгуулаагүй

Байгууллагад үзүүлэх нөлөө / үр дагавар/

Байгууллагын төсвийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх, үр дүн буурах

Зөвлөмж: Үүссэн өглөг, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах

6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
"Сайжруулах шаардлагатай"	Засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: УЛСЫН БАЙЦААГЧ  Б.БАТСАЙХАН

ТАЙЛАН ХЯНАСАН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН

АЛБАНЫ ДАРГА  С.БАРХАСМАА

ТАНИНЦСАН:

ГУРВАНСАЙХАН СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА  Б.ЭНХТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ  Т.ХҮДЭРЧУЛУУН

НЯГТЛАН БОДОГЧ  Б.ЭНХ-АМГАЛАН

АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРГЭН ХЯНАХ

Д/Д	Аудитаар өгсөн зөвлөмжийн агууллага	Зөвлөмжийн дагуу удирдлагын авсан арга хэмжээний биелэлт /биелээгүй бол шалтгаан/	Удирдлагын авсан арга хэмжээ хангалттай эсэх (тийм/үгүй)	Дараагийн аудитаар анхаарах асуудал байгаа эсэх
1	Өр, авлага барагдуулах ажил зохион байгуулах			Тийм

Хянасан:

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч  С.Бархасмаа

Бэлтгэсэн:

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч  Б.Батсайхан